

**МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО  
ДААТГАЛЫН ГАЗАР**

**ДААТГАЛЫН САЛБАРЫН 2011 ОНЫ 3 ДУГААР  
УЛИРЛЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА**

**ТАНИЛЦСАН:**

ХОРООНЫ ДАРГА	Д. БАЯРСАЙХАН
ХОРООНЫ ГИШҮҮН	Г. ХЭРЛЭН
ХОРООНЫ ГИШҮҮН	Б. ДААЖАМБА
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА	Х. БУМ-ЭРДЭНЭ

**ХЯНАСАН:**

ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА	С. ГАНБОЛД
ДААТГАЛЫН ГАЗРЫН БТХ-ИЙН ДАРГА	П. ЦЭРЭНДЭЖИД

**БОЛОВСРУУЛСАН:**

ДААТГАЛЫН ГАЗРЫН ХЯНАН ШАЛГАГЧ	Э. ЭРДЭНЭТУЯА
--------------------------------	---------------

УЛААНБААТАР ХОТ

2011 ОН

## ГАРЧИГ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.ДААТГАЛЫН САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

- 1.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ
- 1.2 ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ
- 1.3 ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ
- 1.4 ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО
- 1.5 ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР
- 1.6 ДААТГАЛЫН НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН
- 1.7 ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА
- 1.8 ДААТГАЛЫН НӨӨЦ САН
- 1.9 ДАВХАР ДААТГАЛ

### ХОЁРДУГААР БҮЛЭГ.ЕРДИЙН ДААТГАЛ

- 2.1 ЕРДИЙН ДААТГАЛ
- 2.2 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ
- 2.3 ЕРДИЙН ДААТГАЛЫН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ
- 2.4 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО
- 2.5 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР
- 2.6 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН
- 2.7 ЕРДИЙН ДААТГАЛЫН АШИГТ АЖИЛЛАГАА
- 2.8 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САН
- 2.9 ЕРДИЙН ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ
- 2.10 МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСАН ДААТГАЛЫН ТАЛААР

### ГУРАВДУГААР БҮЛЭГ.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ

- 3.1 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ, ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ
- 3.2 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ОРЛОГО, НӨХӨН ТӨЛБӨР
- 3.3 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН АШИГ, НӨӨЦ САН

### ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

- 4.1 ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ
- 4.2 ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

### ДҮГНЭЛТ

# ДААТГАЛЫН САЛБАРЫН 2011 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ, ДААТГАЛЫН САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

### 1.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2011 оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын зах зээл дээр ердийн болон урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг 17 компани, 152 даатгалын салбар, 2080 даатгалын төлөөлөгч, 8 даатгалын зуучлагч компани, 8 даатгалын хохирол үнэлэгч компани, 12 актуарч, нийт 2125 тусгай зөвшөөрөл эзэмшигчид үйл ажиллагаагаа явуулж байна.

(Хүснэгт-1)

#### Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо

д/д	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	2009-III	2010-III	2011-III
1	Даатгагч	17	16	17
	Даатгалын компанийн салбар	130	136	152
2	Даатгалын төлөөлөгч	1639	1998	2080
3	Даатгалын зуучлагч	4	8	8
4	Даатгалын хохирол үнэлэгч		6	8
5	Даатгалын актуарч		10	12
	<b>Бүгд</b>	<b>1660</b>	<b>2038</b>	<b>2125</b>

Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо нь энэ оны 3 дугаар улирлын байдлаар 2010 оны мөн үеэс 1.04 дахин өссөн үзүүлэлттэй байна. Үүнд мэргэжлийн оролцогчдын тооны өсөлт нөлөөлсөн байна.

(График-1)




## 1.2 ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ

2011 оны 3 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй 17 компанийн хөрөнгийн нийт хэмжээ 77.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31.4 тэрбум төгрөг буюу 1.7 дахин өссөн байна. Мөн 2008 оны мөн үетэй харьцуулахад 38.2 тэрбум төгрөг буюу 2.0 дахин өссөн дүнтэй байна.

(График-2)

Даатгалын компаниудын хөрөнгий н хэмжээ



Даатгалын салбарын нийт эргэлтийн хөрөнгө 2010 оны 3 дугаар улиралд 41.3 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 89.7 хувь, эргэлтийн бус хөрөнгө нь 4.7 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 10.3 хувийг эзэлж байсан бол 2011 оны мөн үед эргэлтийн хөрөнгө 61.4 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 79.3 хувь, эргэлтийн бус хөрөнгө 16.0 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 20.7 хувийг эзэлж байна.

Даатгалын компаниудын эргэлтийн хөрөнгө өмнөх оны мөн үеийнхээс 1.5 дахин өссөн нь дүрмийн сангийн доод хэмжээг нэмсэнтэй холбоотой юм. Харин нийт хөрөнгөд эргэлтийн бус хөрөнгийн эзлэх хувийн жин өмнөх оны мөн үеэс өсч, эргэлтийн хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хувийн жин буурсан байна. Үүнд эргэлтийн бус хөрөнгө дэх үндсэн хөрөнгийн өсөлт, хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгийн өсөлтүүд нөлөөлсөн.

## Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө

Үзүүлэлтүүд	2010-III		2011-III		Өсөлт/ бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	пункт
Эргэлтийн хөрөнгө	41298.1	89.7	61360.0	79.3	20561.9	-10.4
Эргэлтийн бус хөрөнгө	4735.9	10.3	16038.4	20.7	11302.5	10.4
Нийт хөрөнгө	46034.0	100.0	77398.5	100.0	31864.4	-

2011 оны 3 дугаар улирлын байдлаар эргэлтийн хөрөнгийн 62.97 хувийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, 26.19 хувийг богино хугацаат хөрөнгө оруулалт, 9.82 хувийг дансны авлага, үлдэх 1.02 хувийг бусад эргэлтийн хөрөнгө эзэлж байсан байна. Эргэлтийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад богино хугацаат хөрөнгө оруулалт 2.95 пунктээр өсч, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 0.71 пунктээр, дансны авлага 0.01 пунктээр, бусад эргэлтийн хөрөнгө 2.23 пунктээр тус тус буурсан байна.

Эргэлтийн хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеийнхээс 20.1 тэрбум төгрөгөөр өссөн байгаа бөгөөд үүнд шинээр тусгай зөвшөөрөл авсан “Моннис даатгал” ХХК, “Мандал женерал даатгал” ХХК-иудын дүрмийн сангийн мөнгөн хөрөнгө нөлөөлж байна.

(Хүснэгт-3)

## Эргэлтийн хөрөнгө

Үзүүлэлтүүд	2010-03 улирал		2011-03 улирал		Өөрчлөлт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	26,296.90	63.68	38,637.10	62.97	12,340.20	(0.71)
Богино хугацаат хөрөнгө оруулалт	9,598.80	23.24	16,070.70	26.19	6,471.90	2.95
Дансны авлага	4,058.90	9.83	6,026.10	9.82	1,967.20	(0.01)
Бусад эргэлтийн хөрөнгө	1,343.50	3.25	626.10	1.02	(717.40)	(2.23)
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>41,298.10</b>	<b>100.00</b>	<b>61,360.00</b>	<b>100.00</b>	<b>20,061.90</b>	<b>-</b>

2011 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй даатгалын компаниудыг хөрөнгийн хэмжээгээр нь жагсаахад “Монгол даатгал” ХХК 18.9 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр даатгалын зах зээл дээрх нийт хөрөнгийн 24.5 хувийг эзэлж байгаа бол “Жонон даатгал” ХХК хамгийн бага буюу 1.3 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр зах зээлийн нийт хөрөнгийн 1.7 хувийг эзэлж байна.

Даатгалын зах зээл дээрх нийт хөрөнгийн 40.9 хувийг “Монгол даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Мандал женерал даатгал” ХХК-ийн хөрөнгө бүрдүүлж байна.

(Хүснэгт-4)


д/д	Даатгалын компанийн нэр	Нийт хөрөнгийн хэмжээ	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	5,119.1	6.6
2	Бодь даатгал ХХК	6,537.0	8.4

3	Ган зам даатгал ХХК	1,999.0	2.6
4	Мандал женерал даатгал ХХК	6,164.7	8.0
5	Жонон даатгал ХХК	1,339.4	1.7
6	Миг даатгал ХХК	5,053.4	6.5
7	Монгол даатгал ХХК	18,961.4	24.5
8	Монгол траст холдинг даатгал ХХК	1,663.4	2.1
9	Моннис даатгал ХХК	1,884.1	2.4
10	Мөнх даатгал ХХК	1,704.0	2.2
11	Номин даатгал ХХК	3,788.2	4.9
12	Нэйшнл лайф даатгал ХХК	3,394.6	4.4
13	Практикал даатгал ХХК	4,799.3	6.2
14	Тэнгэр даатгал ХХК	5,522.9	7.1
15	Соёмбо даатгал ХХК	5,616.8	7.3
16	УБ даатгал ХХК	1,898.9	2.5
17	Улаанбаатар хотын даатгал ХХК	1,952.3	2.5
	<b>ДҮН</b>	<b>77,398.5</b>	<b>100.0</b>

### 1.3 ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид даатгалын нөөц сан, эзэмшигчдийн өмч, өр төлбөрийн эзлэх хувь хэмжээг сүүлийн 3 жилийн 3 дугаар улирлын байдлаар харьцуулж харахад дараахь байдалтай байна.

(График-3)



Даатгалын нөөц сан нийт өр төлбөр эзэмшигчдийн өмчид 2009 оны 3 дугаар улиралд 59.7 хувийг эзэлж байсан бол 2010 оны 3 дугаар улиралд 58.3 хувь, 2011 оны 3 дугаар улиралд 44.9 хувь эзлэх болж тус тус буурсан нь нэгдүгээрт, актуар тооцоололд хяналт тавих чадавхи сул, хоёрдугаарт, ашгаа өндөр гаргах гэсэн даатгалын компанийн ашиг сонирхолтой холбоотой байна.

Эзэмшигчдийн өмчийн нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмчид эзлэх хувийн жин 2009 оноос хойш тогтвортой өсч ирсэн байна. Харин өр төлбөрийн дүн мөн онд 7.1 хувь байсан бол тайлант онд 6.3 хувь болж буурсан байна.

(Хүснэгт-5)

**Эзэмшигчдийн өмч**

*/сая төгрөгөөр/*

Санхүүгийн үзүүлэлт	2010 - III		2011 - III		Өсөлт бууралт	
	тоо	эзлэх хувь	тоо	эзлэх хувь	тоо	эзлэх хувь
Эзэмшигчдийн өмч	12191.6	72.9	29654.4	78.4	17462.8	5.5
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	4540.5	27.1	8186.3	21.6	3645.8	-5.5
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>16732.1</b>	<b>100.0</b>	<b>37840.7</b>	<b>100.0</b>	<b>21108.6</b>	

Тайлант үеийн эзэмшигчдийн өмчийн дүн 2010 оны мөн үеийнхтэй харьцуулахад 21.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Хуримтлагдсан ашиг сүүлийн 2 жилд тогтвортой нэмэгдэж ирсэн бөгөөд энэ нь даатгалын компаниудын цэвэр ашгийн өсөлттэй уялдаатай байна.

**1.4 ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО**

Тайлант хугацаанд даатгалын салбарын нийт хураамжийн орлогын хэмжээ 2011 оны 3 дугаар улиралд 36054.6 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.6 дахин өссөн байна. Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан ердийн даатгагчид нийт 35826.7 сая төгрөг, урт хугацааны даатгагч 227.9 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Ердийн даатгалын орлого өмнөх оны мөн үеийнхээс 12875.0 сая төгрөгөөр, урт хугацааны даатгалын орлого 67.4 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Даатгалын гэрээнүүдийн нийт үнэлгээ нь 576123.4 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Даатгалын хэлбэрээр 2011 оны 3 дугаар улирлын нийт хураамжийн орлогыг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад хөрөнгийн даатгал 4125.8 сая төгрөгөөр, автотээврийн хэрэгслийн даатгал 3980.3 сая төгрөгөөр, агаарын хөлгийн даатгал 2016.2 сая төгрөгөөр, хариуцлагын даатгал 1468.4 сая төгрөгөөр, гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 1297.7 сая төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 580.3 сая төгрөгөөр, ачааны даатгал 301.6 сая төгрөгөөр, эрүүл мэндийн даатгал 39.5 сая төгрөгөөр, хуримтлалын даатгал 58.4 сая төгрөгөөр, тэтгэврийн даатгал 35.9 сая төгрөгөөр, санхүүгийн даатгал 223.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, барилга угсралтын даатгал 1118.8 сая төгрөгөөр, хугацаат амьдралын даатгал 66.4 сая төгрөгөөр, мал амьтдын даатгал 0.2 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

(Хүснэгт-6)

*/сая төгрөгөөр/*

Даатгалын хэлбэр	2010.09.30	2011.09.30	Өөрчлөлт /+, /-
	Даатгалын нийт хураамжийн орлого	Даатгалын нийт хураамжийн орлого	
1.2. Хөрөнгийн даатгал	5 190.7	9316.5	4125.8
1.3. Авто тээврийн хэрэгслийн даатгал	5 207.2	9187.5	3980.3
1.8. Агаарын хөлгийн даатгал	2 062.7	4078.9	2016.2
1.10. Хариуцлагын даатгал	3 144.9	4613.3	1468.4
1.1. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	2 822.4	4120.1	1297.7

1.9. Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	1 761.1	2341.4	580.3
1.11. Санхүүгийн даатгал	977.6	1201.1	223.5
1.5. Барилга угсралтын даатгал	1 294.5	175.7	-1118.8
1.4. Ачааны даатгал	489.0	790.6	301.6
2.1. Хугацаат амьдралын даатгал	129.2	62.8	-66.4
2.5. Эрүүл мэндийн даатгал	30.9	70.4	39.5
1.7. Мал амьтдын даатгал	1.6	1.4	-0.2
1.6. Газар тариалангийн даатгал			0.0
2.3. Хуримтлалын даатгал	0.4	58.8	58.4
2.4 Тэтгэврийн даатгал		35.9	35.9
<b>ДҮН</b>	<b>23112.2</b>	<b>36054.4</b>	<b>12942.2</b>

## 1.5 ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

2011 оны 3 дугаар улиралд нийт 6583.7 сая төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосон байна. Тайлант хугацаанд өмнөх оны мөн үеийнхээс барилга угсралтын даатгал 89.0 сая төгрөгөөр, мал амьтдын даатгал 3.8 сая төгрөгөөр тус тус буурч, хөрөнгийн даатгал 120.0 сая төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн даатгал 958.8 сая төгрөгөөр, агаарын хөлгийн даатгал 3.9 сая төгрөгөөр, хариуцлагын даатгал 131.1 сая төгрөгөөр, гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 288.5 сая төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 116.5 сая төгрөгөөр, санхүүгийн даатгал 233.6 сая төгрөгөөр, ачааны даатгал 33.6 сая төгрөгөөр, хугацаат амьдралын даатгал 10.5 сая төгрөгөөр, эрүүл мэндийн даатгал 9.9 сая төгрөгөөр, хуримтлалын даатгал 11.8 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэйгээр нөхөн төлбөрт олгогджээ.

(Хүснэгт-7)  
/сая төгрөгөөр/

Даатгалын хэлбэр	Даатгалын нийт нөхөн төлбөр		Өөрчлөлт
	2010.09.30	2011.09.30	
1.2. Хөрөнгийн даатгал	880	1000	120
1.3. Автотээврийн хэрэгслийн даатгал	2212.1	3170.9	958.8
1.8. Агаарын хөлгийн даатгал	1.7	5.6	3.9
1.10. Хариуцлагын даатгал	159.6	290.7	131.1
1.1. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	514.8	803.3	288.5
1.9. Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	557.4	673.9	116.5
1.11. Санхүүгийн даатгал	305.2	528.8	223.6
1.5. Барилга угсралтын даатгал	89		-89
1.4. Ачааны даатгал	29.5	63.1	33.6
2.1. Хугацаат амьдралын даатгал	5.8	16.3	10.5
2.5. Эрүүл мэндийн даатгал	3.6	13.5	9.9
1.7. Мал амьтдын даатгал	9.6	5.8	-3.8
1.6. Газар тариалангийн даатгал			0
2.3. Хуримтлалын даатгал		11.8	11.8
<b>ДҮН</b>	<b>4768.4</b>	<b>6583.7</b>	<b>1815.4</b>



## 1.6 ДААТГАЛЫН НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН

2011 оны 3 дугаар улиралд даатгалын нөхөн олговрын түвшин даатгалын салбарын дүнгээр 30.4 хувь болж 2010 оны мөн үеийнхээс 3.1 пунктээр буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд сүүлийн 3 жилийн дундаж түвшин 31.2 хувьтай байна.

(График-4)



Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг даатгалын нөхөн олговрын түвшингээр харьцуулахад 2011 оны 3 дугаар улирлын байдлаар “Жонон даатгал” ХХК 99.4 хувь, “Соёмбо даатгал” ХХК 36.3 хувь, “Номин даатгал” ХХК 40.9 хувьтай буюу хамгийн өндөр хувьтай байна.

(Хүснэгт-8)

д/д	Даатгалын компаниудын нэрс	Хохирол нөхөлтийн түвшин		Өсөлт бууралт /пунктээр/
		2010-03	2011-03	
1	Ард даатгал ХХК	39.72	31.2	-8.57
2	Бодь даатгал ХХК	25.26	26.3	1.01
3	Ган зам даатгал ХХК	9.56	7.8	-1.75
4	Мандал женерал даатгал ХХК	0	0.0	0.00
5	Жонон даатгал ХХК	19.83	99.4	79.58
6	Миг даатгал ХХК	24.87	27.0	2.10
7	Монгол даатгал ХХК	47.19	35.1	-12.13
8	Монгол траст холдинг даатгал ХХК	1.35	24.3	22.96
9	Моннис даатгал ХХК	0	10.3	10.32
10	Мөнх даатгал ХХК	19.1	19.0	-0.05
11	Номин даатгал ХХК	36.12	40.9	4.81
12	Нэйшнл лайф даатгал ХХК	27.63	24.3	-3.32
13	Практикал даатгал ХХК	19.69	16.3	-3.41
14	Тэнгэр даатгал ХХК	42.65	30.3	-12.38
15	Соёмбо даатгал ХХК	17.6	36.3	18.70
16	УБ даатгал ХХК	16.64	32.8	16.21

17	Улаанбаатар хотын даатгал ХХК	33.51	20.6	-12.91
	ДҮН	33.5	30.4	-3.10

Даатгалын компаниудаас 2010 оны 3 дугаар улиралд даатгуулагчдад олгосон даатгалын хохирол нөхөлтийн түвшинг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад “Бодь даатгал” ХХК 1.01 пунктээр, “Миг даатгал” ХХК 2.10 пунктээр, “Монгол траст холдинг даатгал” ХХК 22.96 пунктээр “Номин даатгал” ХХК 4.81 пунктээр, “УБ даатгал” ХХК 16.21 пунктээр “Соёмбо даатгал” ХХК /хуучин нэрээр “Түшиг даатгал” ХХК/, 18.7 пунктээр өсч “Мөнх даатгал” ХХК 0.05 пунктээр, “Практикал даатгал” ХХК 3.41 пунктээр, “Ард даатгал” ХХК 8.57 пунктээр, “Ган зам даатгал” ХХК 1.75 пунктээр, “Тэнгэр даатгал” ХХК 12.38 пунктээр, “Монгол даатгал” ХХК 12.13 пунктээр, “Нэйшнл лайф даатгал” ХХК 3.32 пунктээр, “Улаанбаатар хотын даатгал” ХХК 12.91 пунктээр тус тус буурсан байна.

### 1.7 ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА


2011 оны 3 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагуудын тайлант үеийн цэвэр ашиг 6360.2 сая төгрөг байна.

(Хүснэгт-9)

д/д	Даатгалын компаниуд	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	500.8	7.9
2	Бодь даатгал ХХК	808.9	12.7
3	Ган зам даатгал ХХК	316.6	5.0
4	Мандал женерал даатгал ХХК	(110.0)	
5	Жонон даатгал ХХК	20.8	0.3
6	Миг даатгал ХХК	513.7	8.1
7	Монгол даатгал ХХК	1,721.7	27.1
8	Монгол траст холдинг даатгал ХХК	69.8	1.1
9	Моннис даатгал ХХК	166.5	2.6
10	Мөнх даатгал ХХК	8.2	0.1
11	Номин даатгал ХХК	464.4	7.3
12	Нэйшнл лайф даатгал ХХК	(183.5)	
13	Практикал даатгал ХХК	943.8	14.8
14	Тэнгэр даатгал ХХК	495.4	7.8
15	Соёмбо даатгал ХХК	293.2	4.6
16	УБ даатгал ХХК	162.8	2.6
17	Улаанбаатар хотын даатгал ХХК	167.1	2.6
	<b>ДҮН</b>	<b>6,360.2</b>	<b>100.0</b>

2011 оны 3 дугаар улиралд “Нэйшнл лайф даатгал” ХХК 183.5 сая төгрөг, “Мандал женерал даатгал” ХХК 110.0 сая төгрөгийн тус тус алдагдалтай ажилласан ба энэ нь нийт даатгалын салбарын хэмжээний тайлант үеийн цэвэр ашгийг бууруулахад нөлөөлсөн байна.


(График-5)



## 1.8 ДААТГАЛЫН НӨӨЦ САН

Даатгалын нөөц сангийн үлдэгдлийг сүүлийн 3 жилийн байдлаар зэрэгцүүлж үзэхэд тогтвортой өсч ирсэн байна. 2009 оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын нөөц 16.4 тэрбум байсан бол 2010 оны мөн үед 26.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 10.3 тэрбумаар нэмэгдсэн байна. 2011 оны мөн үед даатгалын нөөц сангийн үлдэгдэл 2010 оны мөн үеийнхээс 8.0 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Харин даатгалын нөөц сангийн эзэмшигчийн өмч, өр төлбөртэй харьцуулсан харьцаа сүүлийн 3 жилийн хугацаанд буурч ирсэн байна.


(График-6)



## 1.9 ДАВХАР ДААТГАЛ

2011 оны 3 дугаар улиралд даатгалын компаниуд гадаадын давхар даатгалын компаниудад их хэмжээний даатгалын эрсдэлээ давхар даатгуулж 8.7 тэрбум төгрөгийн хураамж төлсөн нь өнгөрөгч оны мөн үетэй харьцуулахад 2.3 тэрбум төгрөгөөр буюу 1.4 дахин өссөн дүнтэй гарсан байна.

(График-7)



(Хүснэгт-10)

(сая төгрөгөөр)

д/д	Компанийн нэр	2010-III		2011-III		Өөрчлөлт	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1	Ард даатгал	256.3	4.00	1357.3	15.55	1101	11.55
2	Бодь даатгал	2738.4	42.72	2933.5	33.60	195.1	(9.12)
3	Тэнгэр даатгал	1183.2	18.46	279.2	3.20	-904	(15.26)
4	Практикал даатгал	106.3	1.66	188.5	2.16	82.2	0.50
5	Миг даатгал	673.5	10.51	938.9	10.76	265.4	0.25
6	Монгол даатгал	1095.4	17.09	517.5	5.93	-577.9	(11.16)
7	Номин даатгал	123.3	1.92	95.2	1.09	-28.1	(0.83)
8	Нэйшнл лайф даатгал	50.7	0.79	56.5	0.65	5.8	(0.14)
9	Гранд даатгал	183	2.85	-	-	-183	(2.85)
10	УБ даатгал		0.00	23.4	0.27	23.4	0.27
11	Соёмбо даатгал		0.00	1557.6	17.84	1557.6	17.84
12	Улаанбаатар хотын даатгал		0.00	27	0.31	27	0.31
13	Ган зам даатгал		0.00	101.7	1.17	101.7	1.17
14	Моннис даатгал		0.00	653.1	7.48	653.1	7.48
	<b>Дүн</b>	<b>6410.1</b>	<b>100</b>	<b>8,729.40</b>	<b>100</b>	<b>2319.3</b>	<b>0.00</b>

2011 оны 3 дугаар улиралд гадаадын давхар даатгалын компаниудад шилжүүлсэн давхар даатгалын хураамжийн хэмжээг 2010 оны мөн үеийнхтэй харьцуулахад “Ард даатгал” ХХК 1101.0 сая төгрөгөөр, “Бодь даатгал” ХХК 195.1 сая төгрөгөөр, “Практикал даатгал” ХХК 82.2 сая төгрөгөөр, “Миг даатгал” ХХК 265.4 сая төгрөгөөр, “Нэйшнл лайф даатгал” ХХК нь 5.8 сая төгрөгөөр тус тус давхар даатгалын хураамжийн хэмжээгээ нэмэгдүүлж, “Тэнгэр даатгал” ХХК 904.0 сая төгрөг, “Монгол даатгал” ХХК 577.9 сая төгрөг, “Номин даатгал” ХХК 28.1 сая төгрөгөөр тус тус бууруулсан байна.

2011 онд шинээр “УБ даатгал” ХХК, “Соёмбо даатгал” ХХК, “Улаанбаатар хотын даатгал” ХХК, “Ганзам даатгал” ХХК, “Моннис даатгал” ХХК-иуд өөрсдийн эрсдэлээ даатгуулахаар гадаадын давхар даатгагчид даатгуулсан нь 2011 оны давхар даатгалын хураамжийг 1.3 дахин өсөхөд нөлөөлсөн байна

## ХОЁРДУГААР БҮЛЭГ.ЕРДИЙН ДААТГАЛ

### 2.1 ЕРДИЙН ДААТГАЛ

2011 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 16 ердийн даатгагч үйл ажиллагаа явуулж байна. Ердийн даатгалын компанийн салбар 152 болсон бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 16-аар нэмэгдсэн байна.

### 2.2 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ

Энэ оны 3 дугаар улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 16 даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ 74.0 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 29.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.



### 2.3 ЕРДИЙН ДААТГАЛЫН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ

Эзэмшигчийн өмчийн нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмчид эзлэх хувийн жин 2009 оноос тогтвортой өссөн байна.

Санхүүгийн үзүүлэлт	2010 - III		2011 - III		Өсөлт бууралт	
	тоо	ЭЗЛЭХ хувь	тоо	ЭЗЛЭХ хувь	тоо	ЭЗЛЭХ хувь
Эзэмшигчдийн өмч	10848	68.62	19717.9	68.77	8869.9	0.15
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	4961.5	31.38	8954.4	31.23	3992.9	(0.15)
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>15809.5</b>	<b>100</b>	<b>28672.3</b>	<b>100</b>	<b>12862.8</b>	

Энэ оны эзэмшигчийн өмчийн нийт дүн өмнөх оны мөн үеийнхээс тогтвортой өссөн байна.

#### 2.4 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО

Тайлант үед ердийн даатгалын компаниуд 35826.7 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Ердийн даатгалын компаниуд даатгалын нийт хураамжийн орлогын 8672.9 сая төгрөг буюу 24.2 хувийг давхар даатгалд, 119.4 сая төгрөг буюу 0.3 хувийг буцаасан даатгалын хураамжид төлж, 27034.4 сая төгрөгийн даатгалын цэвэр хураамжийн орлоготой ажилласан байна.

Даатгалын компаниудыг 2011 оны 3 дугаар улиралд олсон даатгалын нийт хураамжийн орлогоор жагсаахад нийт хураамжийн орлогын 24.9 хувь буюу 8932.7 сая төгрөгийг “Монгол даатгал” ХХК бүрдүүлсэн бол “Бодь даатгал” ХХК нийт хураамжийн орлогын 16.0 хувь буюу 5732.4 сая төгрөгийг, “Миг даатгал” ХХК нийт хураамжийн орлогын 10.5 хувь буюу 3775.7 сая төгрөгийг тус тус бүрдүүлснээр эдгээр компаниудын даатгалын хураамжийн орлого нийт зах зээлийн 51.0 хувийг эзэлсэн байна.

д/д	Даатгалын компаниуд	Даатгалын хураамжийн орлого	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	4,146.9	11.6
2	Бодь даатгал ХХК	5,732.4	16.0
3	Ган зам даатгал ХХК	546.1	1.5
4	Мандал женерал даатгал ХХК	11.3	0.0
5	Жонон даатгал ХХК	89.0	0.2
6	Миг даатгал ХХК	3,775.7	10.5
7	Монгол даатгал ХХК	8,932.7	24.9
8	Монгол траст холдинг даатгал ХХК	4.9	0.0
9	Моннис даатгал ХХК	1,150.0	3.2
10	Мөнх даатгал ХХК	400.4	1.1
11	Номин даатгал ХХК	1,761.4	4.9
12	Практикал даатгал ХХК	1,960.6	5.5
13	Тэнгэр даатгал ХХК	2,884.4	8.1
14	Соёмбо даатгал ХХК	3,511.2	9.8
15	УБ даатгал ХХК	439.9	1.2
16	Улаанбаатар хотын даатгал ХХК	479.8	1.3
	<b>ДҮН</b>	<b>35,826.7</b>	<b>100.0</b>

## 2.5 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

2011 оны 3 дугаар улирлын байдлаар 6542.3 сая төгрөгийн нөхөн төлбөр олгожээ. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 1.4 дахин өссөн байна.

“Монгол даатгал” ХХК нийт нөхөн төлбөрийн 32.7 хувь, “Ард даатгал” ХХК 10.8 хувь, “Миг даатгал” ХХК 10.3 хувийг тус тус бүрдүүлж нийт зах зээлийн 53.8 хувийг эзэлж байна.

(Хүснэгт-13)

/сая төгрөгөөр/

д/д	Даатгалын компанийн нэр	Даатгалын нөхөн төлбөр	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	703.4	10.8
2	Бодь даатгал ХХК	618.1	9.4
3	Ган зам даатгал ХХК	29.7	0.5
4	Мандал женерал даатгал ХХК	0.2	0.0
5	Жонон даатгал ХХК	198.1	3.0
6	МИГ даатгал ХХК	676.3	10.3
7	Монгол даатгал ХХК	2,138.5	32.7
8	Монгол траст холдинг даатгал ХХК	0.9	0.0
9	Моннис даатгал ХХК	15.4	0.2
10	Мөнх даатгал ХХК	55.3	0.8
11	Номин даатгал ХХК	536.0	8.2
12	Практикал даатгал ХХК	336.1	5.1
13	Тэнгэр даатгал ХХК	641.8	9.8
14	Соёмбо даатгал ХХК	466.6	7.1
15	УБ даатгал ХХК	71.3	1.1
16	УБ хотын даатгал ХХК	54.6	0.8
	<b>ДҮН</b>	<b>6,542.3</b>	<b>100.0</b>

## 2.6 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН

Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг даатгалын нөхөн олговрын түвшингээр харьцуулахад 2011 оны 3 дугаар улирлын байдлаар “Жонон даатгал” ХХК 99.4 хувь “Соёмбо даатгал” ХХК 36.3 хувь, “Номин даатгал” ХХК 40.9 хувьтай буюу хамгийн өндөр хувьтай байна.

(Хүснэгт-14)

/сая төгрөгөөр/

д/д	Даатгалын компанийн нэр	Орлогод тооцсон хураамж	Нөхөн төлбөр	
1	Ард даатгал ХХК	2,258,127,381.00	703 420 606.8	31.2
2	Бодь даатгал ХХК	2,352,644,679.70	618 099 009.0	26.3
3	Ган зам даатгал ХХК	380,113,959.57	29 693 618.0	7.8
4	Мандал женерал даатгал ХХК	1,407,074.30	205 500.0	0.0
5	Жонон даатгал ХХК	199,236,120.00	198 060 000.0	99.4
6	Миг даатгал ХХК	2,507,392,804.00	676 292 555.0	27.0
7	Монгол даатгал ХХК	6,099,158,461.47	2 138 522 356.7	35.1
8	Монгол траст холдинг даатгал ХХК	3,657,660.91	889 123.2	24.3
9	Моннис даатгал ХХК	149,712,151.15	15 451 542.0	10.3

10	Мөнх даатгал ХХК	290,517,278.00	55 332 870.0	19.0
11	Номин даатгал ХХК	1,309,424,737.07	536 004 330.4	40.9
12	Нэйшнл лайф даатгал ХХК	171,400,348.02	41 661 836.7	24.3
13	Практикал даатгал ХХК	2,064,876,337.00	336 101 305.7	16.3
14	Тэнгэр даатгал ХХК	2,119,934,465.46	641 809 082.0	30.3
15	Соёмбо даатгал ХХК	1,285,409,079.00	466 565 711.3	36.3
16	УБ даатгал ХХК	216,842,403.70	71 227 875.0	32.8
17	Улаанбаатар хотын даатгал ХХК	265,341,868.86	54 586 075.0	20.57198
	<b>ДҮН</b>	<b>21,675,196,809.21</b>	<b>6 583 923 396.8</b>	<b>30.37538</b>

## 2.7 ЕРДИЙН ДААТГАЛЫН АШИГТ АЖИЛЛАГАА

2011 оны 3 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагуудын тайлант үеийн цэвэр ашиг 6543.7 сая төгрөг байна. Тайлант үеийн ашиг алдагдлаар нь жагсаахад “Монгол даатгал” ХХК 1721.7 сая төгрөгийн ашигтай ажиллаж нийт зах зээлийн 27.1 хувийг эзэлж байгаа бөгөөд “Практикал даатгал” ХХК 943.8 сая төгрөг буюу 14.8 хувь, “Бодь даатгал” ХХК 808.9 сая төгрөг буюу 12.7 хувь, “Номин даатгал” ХХК 464.4 сая төгрөг буюу 7.3 хувь, “Тэнгэр даатгал” ХХК 495.4 сая төгрөг буюу 7.8 хувь, “Ганзам даатгал” ХХК 316.6 сая төгрөг буюу 5.0 хувийг тус тус эзэлж, эдгээр компаниуд нийт зах зээлийн 74.7 хувийг эзэлсэн байна. Тайлант улиралд ердийн даатгалын компаниуд нэгдсэн дүнгээр ашигтай ажилласан байна.

(Хүснэгт-15)

/сая төгрөгөөр/

д/д	Даатгалын компаниуд	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	500.8	7.9
2	Бодь даатгал ХХК	808.9	12.7
3	Ган зам даатгал ХХК	316.6	5.0
4	Мандал женерал даатгал ХХК	(110.0)	
5	Жонон даатгал ХХК	20.8	0.3
6	Миг даатгал ХХК	513.7	8.1
7	Монгол даатгал ХХК	1,721.7	27.1
8	Монгол траст холдинг даатгал ХХК	69.8	1.1
9	Моннис даатгал ХХК	166.5	2.6
10	Мөнх даатгал ХХК	8.2	0.1
11	Номин даатгал ХХК	464.4	7.3
12	Практикал даатгал ХХК	943.8	14.8
13	Тэнгэр даатгал ХХК	495.4	7.8
14	Соёмбо даатгал ХХК	293.2	4.6
15	УБ даатгал ХХК	162.8	2.6
16	Улаанбаатар хотын даатгал ХХК	167.1	2.6
	<b>ДҮН</b>	<b>6543.7</b>	<b>100.0</b>

## 2.8 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САН

2011 оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын нөөц сангийн үлдэгдлийн 10.34 хувийг учирч болзошгүй хохирлын нөөц сан, 51.84 хувийг орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан,



0.05 хувийг нэхэмжилсэн хохирлын нөөц, 14.82 хувийг учирсан боловч нэхэмжлээгүй нөөц сан, 22.94 хувийг тусгайлсан нөөц сангууд эзэлж байна.

(Хүснэгт-16)

/сая төгрөгөөр/

Нөөц сан	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан	12,059.6	17,517.7	11,643.8	17,933.5
Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан	5,038.2	3,873.5	3,784.0	5,127.8
Нэхэмжилсэн хохирлын нөөц сан	82.9	5,836.9	5,901.7	18.2
Учирч болзошгүй нөөц сан	3,726.7	222.3	370.7	3,578.4
Тусгайлсан нөөц сан	7,802.2	158.0	24.7	7,935.5
<b>ДҮН</b>	<b>28,709.7</b>	<b>27,608.8</b>	<b>21,725.1</b>	<b>34,593.4</b>

Нийт нөхөн төлбөрийн 57.8 хувь нь учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сангаас олгогдсон байна.

## 2.9 ЕРДИЙН ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ

2011 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 8672.9 сая төгрөгийг давхар даатгалд төвлөрүүлсэн байна. “Бодь даатгал” ХХК 33.82 хувь, “Соёмбо даатгал” ХХК 17.96 хувийг тус тус эзэлж нийт давхар даатгагчид төвлөрүүлсэн хөрөнгийн 51.78 хувийг эзэлж байна.

(Хүснэгт-17) /сая төгрөгөөр/

д/д	Компанийн нэр	2011-III	
		тоо	хувь
1	Ард даатгал ХХК	1357.3	15.65
2	Бодь даатгал ХХК	2933.5	33.82
3	Тэнгэр даатгал ХХК	279.2	3.22
4	Практикал даатгал ХХК	188.5	2.17
5	Миг даатгал ХХК	938.9	10.83
6	Монгол даатгал ХХК	517.5	5.97
7	Номин даатгал ХХК	95.2	1.10
8	УБ даатгал ХХК	23.4	0.27
9	Соёмбо даатгал ХХК	1557.6	17.96
10	Улаанбаатар хотын даатгал ХХК	27	0.31
11	Ган зам даатгал ХХК	101.7	1.17
12	Моннис даатгал ХХК	653.1	7.53
	<b>Дүн</b>	<b>8,672.90</b>	<b>100</b>

## 2.9 МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТАЛААР

Малын индексжүүлсэн даатгал /МИД/-ын төсөл нь 2005 оноос эхлэн “ Монгол даатгал” ХХК, “Тэнгэр даатгал” ХХК, “Соёмбо даатгал” ХХК /хуучин нэрээр “Түшиг даатгал”ХХК/, 2006 оноос “Бодь даатгал”, ХХК 2010 оноос “Практикал даатгал” ХХК-иудтай хамтран

малчдын амьжиргааны эх үүсвэр болсон мал сүргийг зуд, байгалийн гамшигт үзэгдлээс хамгаалах тогтолцоог Монгол Улсад анх удаа нэвтрүүлэн ажиллаж байна.

Хорооны 2011 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 177 дугаар тогтоолоор “Малын индексжүүлсэн даатгалыг бүртгэх, тайлагнах түр заавар”-ыг батлан гаргасан бөгөөд уг зааврын дагуу малын индексжүүлсэн даатгалын төслийг хэрэгжүүлж буй ердийн даатгалын компаниудыг орлого урьдчилсан байдлаар дараах байдалтай байна.

(Хүснэгт-18)

/сая төгрөгөөр/

д/д	Компанийн нэр	Малчны төлсөн хураамж	Орлогод тооцсон хураамж	Үйл ажиллагааны зардал	2010 оны нөхөн төлбөр
1	“Монгол даатгал” ХХК	364.4	242.0	121.4	48.1
2	“Практикал даатгал” ХХК	75.9	50.7	25.3	13.7
3	“Тэнгэр даатгал” ХХК	185.7	124.0	61.4	11.2
4	“Бодь даатгал” ХХК	221.2	147.6	73.6	35.3
	Нийт дүн	847.2	564.3	281.7	108.3

Тус компаниуд МИД-ын тайланг 2011оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд тусгаагүй байгаа бөгөөд МИД-ын төсөл хэрэгжүүлэх нэгжтэй тооцоо нийлсэний дараа 2011 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгахаар болсон байна.


## ГУРАВДУГААР БҮЛЭГ.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ

### 3.1 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ, ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ

Даатгалын зах зээл дээр “Нэйшнл лайф даатгал” ХХК нь урт хугацааны даатгалын үйл ажиллагааг 2008 оноос хойш явуулж байна. Байгуулагдсан цагаас хойшхи нийт хөрөнгийн хэмжээ 2130.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Сүүлийн 4 жилийн мөн үеийн байдлаар дараах байдалтай байна.

/График-9 /

/сая төгрөгөөр/



Тайлант хугацаанд гарсан хөрөнгийн огцом өсөлт нь Хорооны 2011 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн тогтоолоор тус компанийн дүрмийн сангийн хэмжээг 3.5 тэрбум болгож нэмэгдүүлсэнтэй холбоотой. Тус компанийн нийт хөрөнгө 2.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

### 3.2 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ОРЛОГО, ДАВХАР ДААТГАЛ, ДАВХАР ДААТГАЛ

Урт хугацааны даатгалын компани 2011 оны 3 дугаар улирлын байдлаар 227.9 сая төгрөгийн орлоготой ажиллаж, 56.5 сая төгрөгийг давхар даатгагчид төвлөрүүлж, 41.6 сая төгрөгийг нөхөн төлбөрт төлжээ. Сүүлийн 4 жилийн байдлаар орлого, давхар даатгал, нөхөн төлбөрийн үзүүлэлтүүдийг хүснэгтээр харуулбал:

(Хүснэгт-19) /сая төгрөгөөр/

	2008.9.30	2009.9.30	2010. 9.30	2011.9.30
Хураамжийн орлого	-	-	160.5	227.9
Давхар даатгал		5.9	50.6	56.5
Нөхөн төлбөр	-	-	30.3	41.6

Тус компани нь 2010 оноос хойш даатгалын хураамжийн орлогыг төвлөрүүлж эхэлсэн байна.

### 3.3 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН АШИГТ АЖИЛЛАГАА, НӨӨЦ САН

Урт хугацааны даатгагч нь 2008 оноос хойш алдагдалтай ажилласаар ирсэн бөгөөд нийт хуримтлагдсан алдагдлын хэмжээ 658.1 сая төгрөгт хүрчээ. Энэ нь нийт эзэмшигчийн өмчийн 18.5 хувийг эзэлж байна.

(Хүснэгт-20) /сая төгрөгөөр/

	2008.9.30	2009.9.30	2010.9.30	2011.9.30
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-195.8	-462.0	-421.0	-658.1
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	-	-121.5	-88.9	-183.5
Нөөц сан	-	-	69.2	164.7

2010 оноос нөөц сангийн тайланг тайлагнасан байна.

(Хүснэгт-21) /сая төгрөгөөр/

Даатгалын нөөц	2008.9.30	2009.9.30	2010.9.30	2011.9.30
Хувь оролцоотой гэрээний нөөц сан	-	-		
Хувь оролцоогүй гэрээний нөөц сан	-	-	69.2	164.7
Хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөц сан	-	-		
ДҮН	-	-	69.2	164.7

Нөөц сан 2011 оны 3 дугаар улирлын байдлаар 164.7 сая төгрөг байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 95.5 сая төгрөгөөр өссөн байна.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

### 4.1 ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ

Тайлант оны 3 дугаар улиралд нийт 8 даатгалын зуучлагч компани үйл ажиллагаа явуулж тайлангаа ирүүлсэн байна. Тайлант улиралд даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын үндсэн үйл ажиллагааны орлого 188.5 сая төгрөг болсон байна.

(Хүснэгт-21)

*/сая төгрөгөөр/*

д/д	Зуучлагч компанийн нэр	2010.09.30	2011.09.30	Өсөлт бууралт
1	“Асимон брокерс” ХХК	28.2	19.6	-8.6
2	“Аме” ХХК	23.5	10.1	-13.4
3	“Ачит ундарга” ХХК	28.2	45.5	17.3
4	“Лоялти солюшн” ХХК	26.7	6.3	-20.4
5	“Эм жи ай би” ХХК	8.3	14.1	5.8
6	“Ренессанс групп” ХХК	3.7	30.4	26.7
7	“Жомолхари” ХХК	0	17.7	17.7
8	“Монголиан интернэшнл брокерс” ХХК	0	44.8	44.8
	<b>Дүн</b>	<b>118.6</b>	<b>188.5</b>	<b>69.9</b>

Хураамжийн орлогыг тайлант оныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Асимон брокерс” ХХК 8.6 сая төгрөгөөр, “Аме” ХХК 13.4 сая төгрөгөөр, “Лоялти солюшн” ХХК 20.4 сая төгрөгөөр тус тус буурч, “Ачит ундарга” ХХК 17.3 сая төгрөгөөр, “Эм жи ай би” ХХК 5.8 сая төгрөгөөр, “Ренессанс групп” ХХК 26.7 сая төгрөгөөр, “Жомолхари” ХХК 17.7 сая төгрөгөөр тус тус өссөн байна. “Монголиан интернэшнл брокерс” ХХК нь 2010 оны 12 дугаар сард тусгай зөвшөөрөл авсан учраас орлого төвлөрүүлээгүй байна.

“Монголиан интернэшнл брокерс” ХХК, “Ачит ундарга” ХХК-иуд нийт даатгалын зуучлалын үндсэн үйл ажиллагааны орлогын 47.9 хувийг эзэлсэн байна.

### 4.2 ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

Тайлант улиралд даатгалын хохирол үнэлэгч компаниудын үндсэн үйл ажиллагааны орлого 141.7 сая төгрөг байна.

(Хүснэгт-22)

*/сая төгрөгөөр/*

д/д	Үнэлэгч компанийн нэр	2010.09.30	2011.09.30	Өсөлт бууралт
1	“Бест эстимэйт” ХХК	10.5	4.7	-5.8
2	“Гэрэгэ эстимэйт” ХХК	5.8	34.2	28.4
3	“Файн эстимэйт” ХХК	3.4	0	-3.4
4	“Итгэлт эстимэйт” ХХК	66.2	71.5	5.3

5	“Мега марз” ХХК	0	5.9	5.9
6	“Вендо” ХХК	5.2	0.4	-4.8
7	“Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК	0	24.9	24.9
	<b>Дүн</b>	<b>91.1</b>	<b>141.6</b>	<b>50.5</b>

Тайлант үеийн хураамжийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Гэрэгэ эстимэйт” ХХК 28.4 сая төгрөгөөр, “Итгэлт эстимэйт” ХХК 5.3 сая төгрөгөөр, “Мега марз” ХХК 5.9 сая төгрөгөөр тус тус өсч, “Бест эстимэйт” ХХК 5.8 сая төгрөгөөр, “Файн эстимэйт” ХХК 3.4 сая төгрөгөөр, “Вендо” ХХК 4.8 сая төгрөгөөр тус тус буурсан байна. “Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК нь 2010 оны 12 дугаар сард тусгай зөвшөөрөл авсан учраас орлого төвлөрүүлээгүй байна.

“Итгэлт эстимэйт” ХХК-ийн даатгалын хохирол үнэлэгч компаниудын нийт орлогын 50.5 хувийг дангаараа эзэлж байна.

## ДҮГНЭЛТ

Даатгалын салбарын хөгжлийн динамик үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг сүүлийн жилүүдийн байдлаар нэгтгэн дүгнэж үзэхэд даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчийн тоо сүүлийн хоёр жилд эрс нэмэгдэх хандлагатай болсон байна.

Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх онуудын мөн үеийнхтэй харьцуулахад 1.7 дахин өсч 77.4 тэрбум төгрөгт хүрсэн байна. Тайлант үеийн цэвэр ашиг 6.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 2.0 дахин өссөн нь даатгалын байгууллагуудын санхүүгийн чадавхи нэмэгдэж, цаашид даатгалын салбарын санхүүгийн үзүүлэлтүүд сайжрах төлөвтэй байгааг илтгэн харуулж байна.

Даатгалын салбарын хэмжээнд тайлант хугацаанд даатгалын компаниудын олсон нийт хураамжийн орлогыг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 36.0 тэрбум төгрөгөөр буюу 1.6 дахин өссөн дүнтэй гарсан нь нэг талаас зах зээлийн хамралт нэмэгдсэн, нөгөө талаас үнийн ерөнхий өсөлттэй холбоотой байна.

Даатгалын зах зээлийн дийлэнх үзүүлэлтүүд эерэг хандлагатай, өсөлттэй гарсан хэдий ч дараахь асуудлуудад анхаарал хандуулах шаардлагатай байна.

1. Монгол Улсад даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй гадаадын даатгагчид шууд даатгуулах явдал их гарч байна. Энэ нь манай дотоодын даатгагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөс гадна Монгол Улсад татвар төлөхгүй байх нөхцөлийг бүрдэж байна.

2. Даатгалын компаниудын санхүүгийн тайлангийн нийт хөрөнгөнд нөөц сангийн эзлэх хувь хэмжээ сүүлийн 3 жил дараалан байнга буурсаар ирсэн нь даатгалын компанийн эрсдэл даах чадавхид сөргөөр нөлөөлөхөөр байна.

3. Салбарын даатгалын гэрээний нийт үнэлгээ 576 173.6 тэрбум төгрөг, даатгалын хураамжийн орлого 36.0 тэрбум төгрөг, үүнээс давхар даатгагчид шилжүүлсэн орлого 8.7 тэрбум төгрөг байна. Эндээс дүгнэвэл даатгалын байгууллагад нийт үнэлгээ буюу эрсдэлийн 75 орчим хувь үлдэж байгаа тул даатгалын салбарын эрсдэлийн удирдлагыг сайжруулах шаардлагатай байна.

4. Салбарын хэмжээнд зарим дүн шинжилгээг хийж үзэхэд хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж нь 46,5 хувь буюу өндөр (*Хөрөнгийн өгөөж = цэвэр орлого/ нийт хөрөнгө*), хөрөнгө оруулалтын өгөөж 4,5 хувь буюу харьцангуй бага (*ХО-ын өгөөж = ХО-ын орлого/нийт хөрөнгө*), орлогын өсөлт сүүлийн 5 жилийн дунджаас 2.7 дахин их байна. Нөхөн олговрын түвшин 30,4 хувь буюу (*Нөхөн олговрын түвшин = Нөхөн төлбөр/ ОТХ*) өмнөх оны мөн үеэс буурсан дүнтэй байна. Ердийн даатгалын ажиллагааны зардлын орлогод тооцсон хураамжид эзлэх хувь хэмжээ (*Ажиллагааны зардал = ҮАЗ/ ОТХ*) 55,8 хувь буюу өндөр байна.

## ДААТГАЛЫН ГАЗАР